

## БНМАУ-Д АЖИЛЛАХ ХҮЧНЭЭ ҮНЭЛҮҮЛСЭН ЯПОНЧУУД (1945.11.20-1947.10.26)

Ж. Урангуа.<sup>1</sup>  
Б. Эрдэнэбилэг.<sup>2</sup>

***Abstract:** Horrific pain, death, suffering and destruction were witnessed by the humanity in the course of two wars that occurred in the twentieth century. This horror is commonly presented by numbers and statistical data. Often, however, this does not fully demonstrate the unbearable harm that an armed conflict causes to mind, soul and mentality of everyone involved. This includes war prisoners who witness their rights and freedoms being snatched away as the consequence of a war.*

*This article focuses on the conditions and labor of the Asia Pacific War (9 August 1945 – 2 September 1945) prisoners held by the People's Republic of Mongolia (the PRM) which was the ally of the Soviet Union during the World War II.*

*The Soviet Union captured 640,105 prisoners after the liberation war against Japan. 609,448 of them were low-ranking officers, soldiers and non-combatants, while 260 prisoners were high-ranking officers. Starting from 20 November 1945 for period of 20 days the PRM received 12,318 prisoners without a name list, which included 15 high-ranking officers, 678 middle-ranking officers, 2,178 low-ranking officers, 8,079 soldiers and 1,368 non-combatants.<sup>3</sup> The prisoners were delivered on 6 separate occasions by truck convoy to the PRM.<sup>4</sup>*

---

1 МУИС, Түүхийн тэнхимд профессор

2 ТЕГ. Тусгай архивын ахлах судлаач

3 General Intelligence Agency, the Special Archives, Fond – 1, SU – 28, p. 32, 1945-1947.

4 General Intelligence Agency, the Special Archives, Fond – 1, SU – 746, p. 52, 1945-1947.ТЕГ.

*These prisoners were forced to engage in hard labor by the PRM between 20 November 1945 and 26 October 1947.<sup>5</sup> This articles unveils the capture, transfer to Mongolia, living conditions and exploitation of these prisoners of war based on the primary source documents obtained from the Special Archives of the General Intelligence Agency of Mongolia and the Central Archives of the Foreign Affairs that were not previously studied.*

**Товч агуулга:** *XX зууны хүн төрөлхтний түүхэн хөгжлийн замд тохиосон хоёр удаагийн их дайн бол үхэл хагацал, эрэмдэг зэрэмдэг болох, өнчрөн хагацахын зовлонг асар ихээр амсуулсан хөнөөлт үзэгдэл байлаа. Судлаачид эдгээр дайны материаллаг хор хөнөөлийг зөвхөн тоо үзүүлэлтээр гаргасаар ирсэн билээ. Гэтэл дайны үйл явц хүний сэтгэл санаа болон оюун ухаан сэтгэхүйд нь учруулсан уршигт үр дагаврыг төдийлөн дурдалгүй, судлалгүй орхин өнгөрөх нь түгээмэл байдаг. Дайны хор хөнөөлийг бие сэтгэлээрээ мэдрэн зовсон хүмүүс бол дайны олзлогдогсод юм. Олзлон авах гэдэг нь “эрх чөлөөт байдлаас эрх болон чөлөөт байдлыг нь хязгаарлах байдалд оруулж буй явдлыг нэрлэнэ” гэж судлаачид үздэг.*

*Энэхүү өгүүлэлд дэлхийн II дайны төгсгөлд болсон Ази, Номхон далайн дайн (1945.8.9-1945.9.2)-д ялалт байгуулсан ЗХУ-ын холбоотон БНМАУ дайны дараа өөрийн газар нутаг дээр олзны хүмүүсийг тодорхой хугацаанд хэрхэн байрлуулж, ажиллуулсан тухайд өгүүлэх болно.*

*Зөвлөлтийн тал Японы эсрэг хийсэн чөлөөлөх дайны үед нийт 640.105 хүн олзолсны бага тушаалын дарга, цэрэг, энгийн япон хүн 609.448, командлалын дээд алба тушаалтан 260 байжээ. БНМАУ 1945 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 20 хоногийн хугацаанд 12318 олзлогдогсдыг нэрсийн жагсаалтгүйгээр тоолон авч, 6 удаагийн цуваагаар Монголд авчирсны дотор ахлах офицер 15, дунд офицер 678, бага дарга 2178, цэрэг 8079, энгийн япон албан хаагчид 1368 байжээ.*

*БНМАУ 1945 оны 11 сарын 20-ноос 1947 оны 10 сарын 26-ны хооронд тэдгээр япончуудыг тус улсад биеийн хүчний хөдөлмөр эрхлүүлж байсан байна. Ингээд бид энэхүү судалгааны өгүүлэлд олзлогдсон япон цэрэг болон энгийн иргэдийг хэрхэн авчирсан, байршуулсан болон хөдөлмөр эрхлэлт, аж байдал ямар байсныг Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив болон Гадаад хэргийн Төв архивт хадгалагдаж буй урд нь судалгааны эргэлтэд төдийлөн ороогүй баримтуудад тулгуурлан дэлгэн тавьсан болно.*

**Түлхүүр үг:** *дайн, гэрээ, олзлогдогсод, хөдөлмөр, өргөдөл, буцагсад*

---

<sup>5</sup> The prisoners discussed herein also include circa 1,000 Inner Mongolian combatants who fought on the side of Japan. (G. Myagmarsambuu, “The Liberation War and Mongolians in the Pursuit of Home” in the Compilation of Presentations at the Conference in Honor of the 70th Anniversary of the Liberation War.)

## Удиртгал

Аливаа дайны материаллаг хохирол, үхэл, сүйрлийг тооцоолон олох амар боловч дайны улмаас гачигдал, өлсгөлөн даван эрүүл мэнд, сэтгэл санааны гүн дарамтад орж, сэтгэлийн шаналал эдэлснийг тооцоолон гаргах боломж бараг үгүй билээ. Дайн өдөөгч орны эрх баригчдын эзлэн түрэмгийлэх бодлогын улмаас тэрхүү орны гэм зэмгүй олон хүн дээрх байдлыг туулан гарахад хүрдэг бөгөөд тэдгээрийн дотор эзэн хаант төрийнхөө үйл хэргийн төлөө тулалдаж яваад бусдын гарт орж, хүнд хүчир амьдралыг туулахад хүрсэн хүмүүсийн нэгээхэн хэсэг бол дайны олзлогдогсод билээ.

Дайны олзлогдогсдын талаарх олон улсын гэрээ хэлцэл байгуулагдсан нь хүн төрөлхтний хөгжлийн шинэ үед буюу 1864 онд тохиож, Женев хотноо Европын 16 орон оролцсон бага хурал хуралдаж, цэргийн олзлогдогсдын талаарх анхны Конвенц батлан гаргажээ. Тус гэрээнд Хаант Орос 1864 онд нэгдэн оржээ. Улмаар дайныг хэрхэн явуулах тухай анхны дүрмийг Гаага хотноо 1899 онд хуралдсан Энх тайвны хурлаар батлан гаргасан бөгөөд түүн дотор цэргийн олзны асуудлыг хэрхэн шийдэж байх талаар заан өгчээ. Дараа нь Гаагын 1907 оны II хурлаар баталсан шинэ Конвенцээр цэргийн олзны цэргүүдийн эрх зүйн хэм хэмжээг тогтоосон байна. Олзлогдох гэдэг нь Тунхаглалд зааснаар: “зөвхөн аюулгүй байдлын үүднээс хоригдлуудын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хэлтрүүлэх үүднээс хорих явдал юм”<sup>6</sup> гэжээ.

Дэлхийн I дайн нь (1914-1918) цэргийн олзлолтын хэм хэмжээг цаашид боловсронгуй болгохыг шаардсан учраас 1929 оны 7 дугаар сарын 27-нд Женевийн конвенц 81 зүйл бүхий 7 хэсэгтэйгээр батлагджээ. Япон улс 1929 онд тус конвенцид нэгдэн оржээ. Ийнхүү дээр дурьдсан олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээр дайны олзны цэргийн асуудлыг шийдэж байсан байна. Орос орон нь Хаант засгийн үед Европынхны даган мөрдөж байсан гэрээнд нэгдэн орсон байсан боловч Зөвлөлт засаг Хаант Орос улсын үеийн бүх гэрээ, хэлэлцээрүүдийг цуцалсан байсан юм. ЗХУ 1939 оны 3 дугаар сарын 19-нд өөрийн дүрмийг тогтоож, дээрхи Женевийн “Цэргийн олзлогдогсодтой харьцах тухай” конвенцийн заалтуудаас арай өөр журмыг тогтоосон байна. Тухайлбал, Зөвлөлтийн тал өрнөдийнхний

6 Международное право в системном изложении /Ф. Лист. – Юрьев/ М., 1909, т. 397

“дайтагч гүрнүүд боломжийнхоо хирээр хорих газарт нэгэн үндэстэн, ястанг хорих явдлаас зайлсхийх ёстой”<sup>7</sup> гэсэн зүйл нь үндэсний болон арьс өнгөөр ялгаварлах явдлыг хуульчилж байна хэмээн үзэж байгаа учир түүнийг дагахгүй гээд өөрийн “ЗХУ-ын Төвийн гүйцэтгэх хороо болон Ардын комиссариатуудын зөвлөлийн тогтоол №46”<sup>8</sup> гэдгийг батлан гаргаж мөрдөх болжээ.

Дэлхийн II дайн эхэлсний дараа 1941 оны 7 дугаар сарын 1-нд Зөвлөлтийн Ардын Комиссариатын газар Цэргийн олзлогдогсдийн талаарх 1939 оны шийдвэрээ эргэн харж, найруулан бичихдээ: дайнд олзлогдогч гэдэг нь: а) ЗХУ-тай дайны байдалд байгаа орны зэвсэгт хүчинд хамаарч, дайны ажиллагааны үед баривчлагдсан хүмүүс болон Зөвлөлтийн газар нутаг дээрх тусгаарлагдсан<sup>9</sup> тэдгээр орнуудын иргэд, б) дайсны зэвсэгт хүчинд үл хамаарах боловч зэвсэглэсэн бүлэгт хамааран илт зэвсэгтэй явж буй этгээд, в) цэргийн үйл ажиллагааны явцад олзлогдсон сурвалжлагчид, ханган нийлүүлэгч, цэргийн хамт зөвшөөрөл бүхий бусад хүмүүс болон дайсны хөлөг онгоцыг дагалдан яваа энгийн иргэд зэрэг болно<sup>10</sup> гэжээ.

Ингээд энэхүү 1941 оны Зөвлөлтийн журмын дагуу Алс Дорнод дахь Чөлөөлөх дайны үед олзлогдсон япон хүмүүс ЗХУ болон БНМАУ-ын газар нутаг дээр<sup>11</sup> байрших болсон юм.

Дэлхийн II дайны жилүүдэд ЗХУ-д ялагдагч орнуудаас 4,126,964 хүн олзлогджээ<sup>12</sup>. Үүний 640.105 нь Японы эсрэг хийсэн дайны олзлоггод байв. Эдгээрийн 62,069 нь 1945-1956 оны хооронд Зөвлөлтийн нутаг дээр нас баржээ<sup>13</sup>. Зөвлөлтийн тал олзлон авсан 600 мянга гаруй япон цэргийн 20 мянган олзлогдогсдыг Монголын талд шилжүүлэхээр БНМАУ-ын удирдлагатай хэлэлцэн тогтсон

7 Кузнецов, С.И. Японцы в сибирском плену (1945-1956 гг.). Иркутск, 1997, т.29

8 Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы / Сост. М.М. Загорулько, С.Г.Сидоров, Т.В. Царевская; Подред. М.М. Загорулько. М.: Логос, 2000 т. 25

9 “таслагдсан” буюу “интернированный” гэх хүмүүсийн асуудал Гаагийн 1899 болон 1907 оны, мөн 1949 оны Женевийн IV конвенцийн “Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай” гэрээнд буй

10 Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы / Сост. М.М. Загорулько, С.Г.Сидоров, Т.В. Царевская; Подред. М.М. Загорулько. М.: Логос, 2000, т. 66

11 Дэлхийн II дайны дараа 1949 оны 8 дугаар сарын 12-нд Женевийн III конвенцээр баталсан “Дайны олзлогдогчидтой харьцах тухай” гэрээнд дэлхийн 166 орон нэгдэн орсон бөгөөд БНМАУ 1958 онд албан ёсоор нэгдэн орсон

12 Военно-исторический журнал. М., 1990, № 9, т. 45

13 Карасев С.В. История плена: советско-японская война и ее последствия: 1945 - 1956 годы. Диссертация. Иркутск, 2007

боловч хэрэг дээрээ Монгол нь 12318 олзлогдогсдыг хүлээн авчээ. Эл үед Монгол улс цэргийн олзлогсдын талаарх ямар нэгэн олон улсын Конвенцид нэгдэн ороогүй байсан хэдүй ч тус орны төр засаг олон улсын хэмжээнд мөрдөж байсан дүрэм журмыг өөрийн оронд хэрэгжүүлсэн нь судалгаанаас харагдаж байна.

**БНМАУ цэргийн олзлогсдыг хүлээн авахад бэлтгэж, тэднийг байршуулсан нь**

Бид ТЕГ-ын Тусгай архивын 1 дүгээр фондын ОЦХЭЕГ-ын хөмрөгийн баримт, мөн Намын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, ДЯЯ-ны удирдлага, захирамжлалын үйл ажиллагаанд холбогдох баримтуудыг ашиглан эл сэдвийг нээн харуулж байгаа бөгөөд энд дурдагдах баримтууд нь анх удаа судалгааны эргэлтэнд орж, нийтийн хүртээл болж байгаагаараа онцлог ажгуу.

ЗХУ-д 1945 оны 8 дугаар сарын 23-ны өдөр И.В.Сталины гарын үсэг зурсан “маш нууц” зэрэглэлтэй “Японы армийн цэргийн олзлогдогсдыг хүлээн авах, байрлуулах, ажил хөдөлмөрт ашиглах” тухай 9898 тоот тогтоолд “...500 мянган япон цэргийг ЗХУ-д албадан хөдөлмөрт илгээх, тэднийг хуваарилан ажиллуулах үйлдвэр, аж ахуйн газруудыг тодорхойлон, японы цэргийн олзлогдогсдын амьдрал, үйл ажиллагааг зохион байгуулах талаарх авах арга хэмжээг заажээ<sup>14</sup>.

Олзлогдсон цэргүүдийг хүлээн авах бэлтгэл ажилтай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 61 дүгээр хурлын шийдвэрээр ДЯЯ-нд “Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах хэлтэс”-ийг байгуулж, удалгүй Газар (Олзлогдсон цэргийн хэргийг эрхлэх ерөнхий газар-ОЦХЭЕГ) болгон эрх хэмжээ, үүргийг нь өндөрсгөсөн байна.

Олзлогдогсдыг юуны түрүүнд орон байраар хангах асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1945 оны 10 дугаар сарын 2-нд БНМАУ-ын СнЗ-ийн 71 дүгээр хурлаас олзлогдсон цэргүүдийг байр сууцаар хангах Төв комиссыг байгуулсан бөгөөд уг комиссын хурлаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Жаргалант, Энх талын сангийн аж ахуй, Улаанбаатар хотын зарим үйлдвэр, аж ахуй, соёлын байгууллагын байрыг олзлогдогсдын сууцанд ашиглах, 200 эсгий гэрийг бэлтгэж,

---

14 Ч.Дашдаваа. Японы олзлогдогсод Монголд. УБ., 2013. т. 20

ОЦХЭЕГ-т шилжүүлэх, Сэлбэ дэх Дамбадаржаа амралтын газрыг хааж, түүний бүх барилгыг олзлогдсон цэргийн эмнэлэг болгохоор шийдвэрлэжээ.<sup>15</sup>

Мөн хүрэлцэн ирэх олзлогдогсдыг хоол хүнсээр хангах тухайд БНМАУ-ын СнЗ-ийн 1945 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 72 дугаар хурлаас баталсан “Олзлогдсон цэргүүдэд хэрэглэгдэх идэш уушны зүйлийг тавин олгох тухай” тогтоолд:

1. Олзлогдсон цэрэг 20 мянган хүнийг (бид Монголд 20 мянган олзлогдогсдыг байршуулахаар тогтсон байсан тухай дээр дурьдсан билээ-Ж.У.) хооллоход 3 сар хүрэлцэх хэмжээний хүнсний зүйлийг Дотоод яамны Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газарт шилжүүлэн өгөхийг Хоршоодын Төв холбооны ерөнхий хорооны дарга, н.Цагаандорж, Худалдааны яамны сайд, н. Лувсанжамьян нарт үүрэг болгох нь. Үүнд:
  - 2 дугаар гурил 18 тонн
  - 3 дугаар гурил 770 тонн /Хүнсний яамны фондоос/
  - Элдэв будаа 130 тонн /цагаан будаа 40 тонн, шар будаа 90 тонн/
  - Гоймон 18 тонн
  - Ёотон 30 тонн /Хүнсний яамны фондоос/
  - Хар ба байхуй цай 3-6 тонн /Худалдааны яамны фондоос/
  - Лаварын навч 1-5 тонн /Хүнсний яамны фондоос/
2. Олзлогдсон цэрэг 20 мянган хүнийг хооллоход 3 сар хүрэлцэх хэмжээний хүнсний зүйлүүдийг Дотоод яамны Олзлогдсон цэргийн лагериудыг удирдах газрын мэдэлд тавин олгохыг Хүнсний үйлдвэрийн яамны сайд, н.Доржготовт үүрэг болгох нь: Үүнд:
  - Элдэв мах 54 тонн /Орон нутгийн фондоос махны ерөнхий балансыг нарийвчлан зохиож гаргах/
  - Шар тос ба өөхний зүйл 27 тонн /Хүнсний яамнаас/
  - Барааны саван 18 тонн /Хүнсний яамны савангийн заводаас/
  - Бүгд 216 тонн давсыг Дотоод яамны Олзлогдсон цэргүүдийн

---

15 “Монгол Японы харилцаа эрт эдүгээ”. УБ., 2001. т. 108-109

лагериудыг Удирдах газарт бэлэн үнээр шилжүүлэн өгөх бөгөөд үүний дотроос олзлогдсон цэргүүдийн 3 сарын хэрэгцээг хангахад юуны өмнө 54 тонн давсыг одоо шилжүүлэн өгөхийг Гар үйлдвэрийн Дээд зөвлөлийн дарга, н.Надмидад даалгасугай.

3. Олзлогдсон цэргүүдийг хүрэлцэн ирмэгц тэдний хоолонд хэрэглэгдэх загасны хэрэгцээг бүрэн хангахаар бодож, тэдний хүчээр Өгийнуураас загас барих ажлыг нэн даруй зохиохыг Дотоод яамны сайд, н.Шагдаржавт үүрэг болгохоос гадна загас барихад чухалчлагдах бүх хэрэгслийг Олзлогдсон цэргүүдийн лагериудыг удирдах газрын мэдэлд нэн даруй шилжүүлж өгөхийг Хүнсний үйлдвэрийн яамны сайд, н. Доржготовт даалгасугай”16 гэснээс үзэхэд 20 мянган олзлогдсон цэрэг хүлээн авахаар анх бэлтгэл ажлуудыг хийж байжээ.

1945 оны 11 дүгээр сарын 10-нд ОЦХЭЕГ-ын даргаас гаргасан 15 тоот тушаалаар Улаанбаатар орчим байрласан япон цэргийг хүлээн авах лагериудыг төв лагерийн дарга, ахмад Чойжамцад харьяалуулж, олзлогдогсдыг хүлээж авах төлөөлөгчийг Сэлэнгийн Сүхбаатар хотод суулгахаар шийдвэрлэж, уг албан тушаалд Х.Цэвэндоржийг томилсон байна.

Ингээд дээрх бүх арга хэмжээг авсны дараа олзлогдогсдыг хүлээн авах арга хэмжээ эхэлжээ. Тэднийг хүлээн авсан тухай архивын баримтыг бүрэн эхээр нь толилуулбал: “Монгол ардын хувьсгалт цэргийн орлогч жанжин дэслэгч генерал Лхагвасүрэн. 1945 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр.

1. Олзлогдсон япончуудыг хүлээлгэх акт.

Нэгэн этгээдээс хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивизийн 19 дүгээр морин хорооны дарга хошууч Нанзаддорж, мөн сургагч хошууч Амирнов, нөгөө этгээдээс олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрын орлогч дарга, хошууч Гончиг, сургагч Русков нар Монголын ардын хувьсгалт цэргийн орлогч жанжны тушаалын ёсоор олзлогдсон япон цэрэг, офицер бүгд 4986 хүнийг нэрсийн жагсаалтгүй ерөнхий тоогоор хүлээн авч,

---

16 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 4, тал 1-3

өгөлцсөн болох бөгөөд эдгээр цэрэг дарга нар болвоос өвөл ба зун цагийн төлөвлөгөөний ёсоор хувцсаар хангасан болохын дээр мөн олзлогдогсдыг хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн 2 сарын бэлтгэл хүнс бүхий болно. Эл актыг 4 хувь бичиж, 1 дүгээр хувийг Байгалийн өмнөд фронтын штабт, 2 дугаар хувийг монголын ардын хувьсгалт цэргийн жанжин штабт, 3 дугаар хувийг Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газарт, 4 дүгээр хувийг Сайд нарын Зөвлөлд тус тус толилуулна.

2. 1945 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр.

Нэгэн этгээдээс олзлогдсон япончуудын харуулын дарга бага лейтенант /дэслэгч/ Хорутков, 35 дугаар армийн Улс төрийн хэлтсийн дарга, ахмад Баторов, нөгөө этгээдээс Монгол улсын СнЗ-ийн дэргэдэх Олзлогдогсдын хэрэг эрхлэх газрын дарга, хошууч генерал Сосорбарам, мөн төлөөлөгч Доржсүрэн нар энэхүү актыг тогтоосон учир энэ өдөр СССР ба Монгол хоёр улсын хил болох Наушки хэмээх газар олзлогдсон япон цэрэг, офицер нийлж бүгд 1404 хүн. Үүний дотор офицер 64, жич морь 22, дугуйтай тэрэг 18 тус тус хүлээлгэн өгч, авалцсан болох ба мөн хүлээн авах явдалд Монгол улсын төлөөлөгчдөөс гомдол гаргасан зүйл үгүй болохыг тэмдэглэж, тус тусын гарын үсгийг зурав.

3. 1945 оны 12 дугаар сарын 4-ний өдөр.

Харуулын дарга, дэслэгч Сулима, хилийн шалган байцаах боомтын дарга Куликовын хамт олзлогдсон япон цэргүүдийг Монгол улсын төлөөлөгчид хүлээлгэн өгсөн нь: Япон цэрэг 1479, морь 126, тэрэг 20 тус тус болно.

4. 1945 оны 12 дугаар сарын 5-ны өдөр.

Гарын үсэг зурагчид. Олзлогдсон 42309 дүгээр цувааны дарга бага дэслэгч Колубцев ба Монгол улсын төлөөлөгч Цэвээндорж нар энэ өдөр 2 улсын хил болох Наушка хэмээх газар хүлээн өгч авсан нь: Байлдаанд олзлогдсон япон цэрэг, бага офицерууд бүгд 1494 хүн, морь 19 толгой, 2 дугуйтай морин тэрэг 47 эдгээрийг Монгол улсын төлөөлөгч Цэвээндоржид хүлээлгэн өгсөн ба хүлээн авсан болно. Энэхүү хүлээлгэн өгч авалцах явдалд

Монгол улсын төлөөлөгчийн зүгээс ямар гомдол гаргасан зүйлгүй тул энэ актад тус тусын гарын үсгийг зурж баглав. Актыг улсын хил дээр 2 хувь бичив.

5. 1945 оны 12 дугаар сарын 9-ний өдөр.

Харуулын дарга лейтенант Фроловоос хязгаарын боомтын дарга Королёвыг байлцуулж, олзлогдсон япончуудыг Монгол улсын төлөөлөгч Цэвээндоржид шилжүүлэн өгсөн нь: Офицер цэрэг нийлж бүгд 1497, морь 22, тэрэг 31 тус тус болно.

6. 1945 оны 12 дугаар сарын 10-ны өдөр.

Энэ актад гарын үсэг зурагчид нь СССР улсын 42306 тоот цувааны харуулын дарга ахлах дэслэгч Шальдин нар нөгөө талаас Монгол улсын цэргийн төлөөлөгч Цэвээндорж нар энэ актын ёсоор хүлээн өгсөн ба хүлээн авсан нь олзлогдсон япончууд бүгд 1458 хүн. Үүнээс 30 хүн хилийг нэвтрээгүй бөгөөд ачааны машин 2, тэрэг 23, морь 16 тус тус болно<sup>17</sup> гэжээ.

Хүлээлцсэн актад ЗХУ-ын цэргийн төлөөлөгч Баторов, Хороков, Сулим, Куликов, Колубцев, Фролов, Шальдин, Королёв, БНМАУ-ын цэргийн төлөөлөгч Нанзаддорж, Бавуу, Цэвээндорж нар гарын үсэг зурсан байна.

ЗХУ-ын Наушка өртөөнөөс БНМАУ-ын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод хүлээн авч, эмнэлгийн үзлэг хийхэд олзлогдогсад бүгд зуны нимгэн хувцастай, замдаа их даарч олон хүн уушгины голдуу өвчтэй байсан ба зам зуур дээрх байдлаас болж 29 хүн нас барсны 15 нь нэр тодорхойгүй акттай байжээ. Олзны хүмүүсийг Сэлэнгэ аймгаас Улаанбаатар хүртэл БХЯ-ны машинаар авчирсан байна. Ийнхүү олзлогдсон япончуудын эхний цуваа Монголд ирсэн байна.

#### **Олзлогсодын биений хүчнийг ашиглах бодлогын хэрэгжилт**

ОЦХЭЕГ-аас 1945 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Намын Төв Хороо, СнЗ-д явуулсан илтгэх хуудсанд:

1. Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газар нь 20 мянган японоос энэ өдөр 5 мянгыг хүлээн аваад байна. Үүний дотроос барилга, цахилгаан, төмөр зам, оёдол, хүн, малын эмч, талх

---

17 ТЕГ. Тусгай архив. Сан 1, хн 2, тал 1-6

- нарийн боов, машины жолооч, слесарь зэрэг тусгай мэргэжлийн хүмүүс 1000 орчим байна.
2. Эдгээр дурдсан мэргэжлийн хүмүүсийг хотын орчим татаж, тэд нарыг өөрийн барих барилгуудад ажиллуулах ба нөгөө мэргэжилгүй хүмүүсийг орон нутагт ажиллуулахаар өөрийн ажлын төлөвлөгөө зохиож байна.
  3. Ирсэн япончуудаас Аж үйлдвэрийн комбинатад 300, Мах комбинатад 439, Налайхад 206, Сүхбаатарын түүхий эдийн баазад 570, Зүрхийн лагерьт 556, Алтанбулагийн булигаарын заводад 156, Зүүнхараагийн лагерьт 411, Жаргалантын аж ахуйд 562, Хужирбуланд япон цэргийн суух байр засуулах ажилд 623, Зүүнбүрэнгийн аж ахуйд 156, Алтанбулагийн цэргийн баазад 11<sup>18</sup> хэмээн илтгэсэн байна.

Энэ баримтаас үзэхэд, японы олзлогдогсдоос 5 хүн тутмын 1 нь ямар нэгэн тусгай мэргэжилтэй байна. Ийнхүү 1929 оны 7 дугаар сарын 27-ны Женевийн конвенцэд цэргийн хорих газар, олзлон авах нөхцөл зэргийн талаар заасан болон олзлогдогсдын хөдөлмөрийг ашиглах-чингэхдээ олзлогдсон эрүүл цэргүүдийн хөдөлмөрийг ашиглахдаа тэдний нийгмийн байдал болон эзэмшсэн мэргэжлийг харгалзан үзэж зохион байгуулна<sup>19</sup> гэсэн заалтыг хэрэгжүүлэх боломж Монголд тухайн үед бүрэлдсэн байна.

БНМАУ-ын Засгийн газар Олзлогдсон цэргүүдийн хэрэг эрхлэх ерөнхий газар, Улсыг аюулаас хамгаалах газрын үйл ажиллагааг зохистой ажиллуулах талаар нэлээд олон төрлийн ажлыг зохион байгуулж байжээ. Тухайлбал: ОЦХЭЕГ-т Шалган байцаах хэлтсийг байгуулсан бөгөөд 1945 оны 12 дугаар сарын 10-нд батлагдсан тус хэлтсийн ажиллах зааварт: “Байцаагч нар нь олзлогдсон офицер, цэргүүд, өвчтөнүүдийн хоолонд нэгэн өдөрт нэг хүнд хэчнээн хэмжээний юу өгөх ёстойг мэдэж, лагерь цэргүүдийн ажилтнуудаас түүнийг норм ёсоор олгож буй эсэхийг шалган үзэж, хоолны амт чанар, хүний биед хортой эсэхийг шалгаж, хоолыг халуунаар нь идүүлж, өдөр тутмын төлөвлөгөөг давуулсан хүнд хоолны нэмэгдэл олгож буй эсэх, олзлогдогсдын хүнсэнд зориулсан зүйлийг олгохгүй

18 ТЕГ. Тусгай архив. Сан 1, хн 26, тал 1-3

19 Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы. М., 2000, т 1017

саатуулж буй хүмүүсийг илрүүлж, тухай бүр арга хэмжээ авахуулах, орон сууц, түлш усны хангамж, хувийн болон орчны ариун цэвэр, хувцаслалт, тэдэнтэй ажиллаж буй монгол ажилтнуудаас гаргаж байгаа үл нийцэх дутагдлыг илрүүлэх, олзлогдогсдыг ажиллуулж байгаа албан үйлдвэрийн газруудаас тэднийг хөдөлмөрт хэрхэн ашигладаг, багаж хэрэгслийн хангалт зэргийг судалж байх”-ыг заажээ. Эдгээр заалтууд нь 1929 оны Женевийн конвенц болон мөн онд батлан олон орон хүлээн зөвшөөрсөн “Цэргийн олзлогдогсодтой харьцах тухай” гэрээний заалтуудад нийцэж байна<sup>20</sup>.

Мөн олзлогдсон цэргүүдийг хүлээн авах ажилтай холбогдуулан ДЯЯ-ны сайдын 1945 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 421 тоот тушаалаар тус яамны Улсын аюулаас сахиж хамгаалах хэргийг удирдах ерөнхий газрын /УАСХХУЕГ/ харьяа 9 дүгээр хэлтсийг байгуулж, 1947 оны 10 дугаар сарын 24-нийг хүртэл 2 жил ажиллуулахдаа японы олзлогдсон цэргийн дотор өөрийн нууц тагнуулын ба гүйцэтгэх ажлыг удирдан зохион байгуулан ажиллуулжээ.<sup>21</sup>

Хүлээн авсан олзны 12318 хүнийг Улаанбаатар хотын хэмжээнд 1 дүгээр колони, 5 дугаар фабрик (ноосны үйлдвэр-Ж.У.), Цагаанхуаран, Амгалан, Хужирбулан, Үйлдвэрийн комбинат, Махкомбинат зэрэг газруудад хуваарилан лагерилуулж, (хүрээлэн буудаллах газар-Ж.У.), 48,1 хувийг нь бүтээн байгуулалтын ажилд Засгийн газар, Дуурийн театр, Гадаад явдлын яам, Номын сан, Кино театр, зочид буудал, Улсын их сургууль, Намын дээд сургууль, Сонгино, Нүхт, зарим орон сууц, албан газрын өргөтгөл дээр, 42,4 хувийг барилгын материал бэлтгэх ажилд хуваарилан Толгойт, Гандан, Сэлбэ, Налайх, Хужирбулангийн тоосгоны үйлдвэр мөн шохой, чулуун завод, Ерөө, Бумбат, Ар хуст, Балж, Туулын мод бэлтгэлийн газруудад ажиллуулж, үлдсэн 9,5 хувийг үйлдвэр, албан газруудад мэргэжлийн дагуу гэрээгээр өгч оёдол, машин засвар, ногоо тариулах зэрэг ажил хийлгэж байжээ.

Мөн олзлогдогсдын нэлээд хэсгийг Архангай аймгийн Өгийнуураас загас бариулах, Борнуур, Батсүмбэр, Жаргалантын сангийн аж ахуйд хүнсний ногоо тариулж, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнхараа, Баруунхараа, Зүүнбүрэн зэрэг газруудад

20 Военнопленные в СССР. 1939-1956. Документы и материалы. М., 2000, т.1017

21 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 392, тал 1

ажиллуулж байжээ.<sup>22</sup> Эдгээр хуваарилагдсан газрыг ажиглаваас Монголын газар тариалангийн бүсүүд бөгөөд тэдний хоол хүнсэнд хэрэглэх зүйлсийг өөрсдөөр нь бэлтгүүлэх зорилготой байжээ.

1946 оны 1 дүгээр сарын 4-нд Олзлогдогсдын хэрэг эрхлэх ерөнхий газраас БНМАУ-ын ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал нарт бичсэн илтгэлд: “Манай улсад хүлээн авсан япон цэргүүд 12318, эдгээрээс элдэв шалтгаанаар нас барсан 202, өвчтэй эмнэлэгт хэвтэж буй 713, одоо үйлдвэр, албан газарт ажиллаж буй 6644, саяхан ирээд амарч буй ба Сүхбаатар хотоос одоогоор ирж амжаагүй машин хүлээж буй 4759 байна” хэмээжээ.

Олзлогдогсдыг батлагдсан нормоор хооллож, бие султай хүмүүсийг тусгайлан авч үзэж сувилах, эмчлэх, зөвхөн япон эмчийн актаар хөдөлмөрөөс чөлөөлөх, сайн ажиллагсдад мөнгөн шагнал, нэмэгдэл хоол өгөх, ажлын бус цагт чөлөөтэй амрах, ар гэртээ захидал, цахилгаан бичих, дэлгүүрт наймаа хийх зэрэг боломжоор хангаж байжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 41 дүгээр хурлын тогтоолоор: “Ажлын нормыг 100 хувиас дээш биелүүлсэн олзлогдогсдод 200 грамм талх, 20 грамм ётон, 40 грамм хиам буюу эс бол хиамны оронд 60 грамм загас буюу 100 грамм цагаан будааг одоо хэрэглүүлж буй хоол хүнсний нормын дээр олгож байхаар тогтоосугай”<sup>23</sup> гэжээ. Энэ тухай олзонд байсан япон цэргүүдийн нэг Шунжи Ватанабэ хожим Монголын “Өдрийн сонин”-д өгсөн ярилцлагандаа: “Ажлаа 100 хувь хийчих юм бол хоол бага зэрэг нэмж өгдөг байсан. Ингэж хоолоо нэмүүлэхийн тулд махран ажилладаг байлаа”<sup>24</sup> хэмээн өгүүлсэн нь дээрхийг илтгэнэ.

Олзлогдогсдын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, амьжиргааг нь сайжруулахад тодорхой хэмжээгээр тус дэм болж байсан бас нэгэн зүйл нь тэдний хөдөлмөрийн хөлсийг мөнгөөр хэмжиж олгож байсан явдал юм. ОЦХЭЕГ-аас олзлогдогсдыг ажиллуулахаар үйлдвэр, аж ахуйн газруудтай байгуулсан гэрээнд: Ажлын нормыг давуулан биелүүлсэн

22 Ч.Лувсан-Очир. Дайны дараа Монголд байсан япончуудын хувь заяа. УБ.,1998. т. 5

23 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 57, тал 5

24 “Өдрийн сонин”. 2011.07.04. №162/3864/

олзлогдсон хүн нэг бүрт мөнгөн шагнал олгох, үүнд: мэргэжлийн ажил хийгчдэд сард 50 төгрөг, бусад ажилд сард 25 төгрөг тус тус олгох, тухайн байгууллагад захиргаа, техникийн үүрэгт ажлыг гүйцэтгэж байгаа мэргэжил бүхий олзлогдогсдод мөнгөн шагнал олгохдоо уул албан тушаалд нь тогтоосон цалингийн зууны тавин хувийг олгох боловч сард 300 төгрөгнөөс хэтрэхгүй байх, бригадын дарга нарт олгох шагнал нь сард 240 төгрөгнөөс хэтрэхгүй байх, ажлын оновчтой санал гаргаж, уг саналыг биелүүлсэн тохиолдолд мөнгөн шагналын тавин хувийг олгох боловч тэр нь тавин хувиас хэтрэхгүй байх, улсаас тогтоосон ажлын нормыг 100-150 хувь, түүнээс дээш хувиар биелүүлсэн салааны даргад 75-250, ротын даргад 100-250 төгрөгийн мөнгөн шагнал олгож байх”-аар зааж, мөрдөн хэрэгжүүлж байв. Үүнээс гадна салаа ба рот нь ажлын нормоо биелүүлээгүй байсан ч салааны даргад 25 төг, ротын даргад 50 төгрөгийн мөнгөн шагнал сар бүр олгож байжээ. Үүнийг Хужирбуланд шохой шатаах шинэ зуух санаачлан амжилт гаргасан бага дарга Тонано, цэрэг Хирихара нарын олон арван хүн мөнгөн ба эд материалаар шагнагдаж байснаас харж болно.

ОЦХЭЭГ-ын даргаас 1946 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хороонд илгээсэн 334 тоот албан бичигт: Олзлогдогсод мөнгөөрөө юм авч чаддаггүй тул нэр бүхий 7 газарт хүнсний зүйл худалддаг мухлагтай болгох зөвшөөрөл олгохыг хүссэнээр удалгүй Хужирбулангийн тоосгоны завод, Хотын тоосгоны завод, Шохойн завод, Гандангийн тоосгоны завод, Намын дээд сургуулийн барилга, хотын төвийн барилгуудын дунд гэх зэрэг нэр бүхий 7 газарт олзлогдогсдод зориулсан хүнсний бүтээгдэхүүн худалддаг мухлагууд байгуулж ажиллуулжээ.

**Олзлогдсон япончуудын ажиллаж байсан барилгууд бол:**

- Засгийн газрын ордны барилга. Суурь тавьсан, зарим хэсэгт өрлөг эхэлсэн.
- Улсын их сургуулийн хоёрдугаар ээлжийн өнгөлгөө, /будгаас бусдыг хийсэн/
- Улсын номын сан дутуу /шавардлага, будаг зэрэг/

- Гадаад яамны барилга, 23 айлын сууцны хамт /будаг, паркет шал зэрэг нарийн ажлыг бид өөрсдийн хүчээр хийсэн/
- Кино театр /Элдэв-Очир/, /будгийн ажлаас бусдыг/
- Намын сургуулийн хичээлийн байрыг дуусгаж, гуанз, клубын суурь тавьж, ханын өрлөг эхэлсэн.
- Амбулатори /1 дүгээр төрөх/ өнгөлгөө дутуу.
- Төв театрын барилга. Суурь тавьж, ханын өрлөг дутуу хийсэн.
- 8 дугаар дэлгүүртэй сууцны барилга барьсан. /дутуу/
- Хотын модон завод, төмрийн тасгийн барилгын их биеийг босгосон.
- Сонгинын амралтын жижиг барилгыг босгосон.
- Тоосго, шохой боловсруулах зэрэг ажилд нэлээд хүмүүс ажиллаж байсан.
- Махкомбинатын зоорь барьсан.
- Төв бараа баазын агуулах барьсан.
- Хотын тоосгоны заводын нэгдүгээр өргөтгөлийг хийсэн.
- Төв Хорооны 12 айлын сууц барьсан ба барилгын халаалт, усны шугам сүлжээг угсарч, тавих ажлыг цахилгаан сантехникийн үйлдвэр гүйцэтгэж байсан байна.25

Ер нийт олзлогдогсдыг хуваарилан ажиллуулж байсан байдлаас үзэхэд, тэдний 90 гаруй хувийг Улаанбаатар хотын барилга, барилгын материал үйлдвэрлэлийн салбарт ажиллуулжээ.

### **Олзлогдогсдыг нутаг буцаах үйл ажиллагаа**

ЗХУ-аас Японы олзлогдогсдыг эх нутагт нь буцаах үйл явц 1946 оны эцсээс эхэлсэнтэй холбоотойгоор Монгол дахь олзлогдогсдыг буцаах асуудал ч нэгэн адил дэвшигдэж, эл хэрэгт Зөвлөлтийн тал ихээхэн анхаарал хандуулах болжээ.

Ийм үед японы олзлогдогсдыг Монголд байлгах хугацааг уртасгах талаар БНМАУ-ын зүгээс ЗХУ-д хүсэлт гаргаж байжээ. Энэ тухай МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал 1947 оны 3 дугаар сарын 22-нд ерөнхий сайд Х.Чойбалсанд Москвагаас

25 Ч.Лувсан-Очир. Дайны дараа Монголд байсан япончуудын хувь заяа. УБ., 1998. т. 17

илгээсэн цахилгаан утсандаа: “...Гадаад яамны орлогч сайд Маликтай уулзаж, манайд байгаа олзлогдсон япончуудыг энэ жилийн дулааны улирлыг дуустал барилга дээр ажиллуулбал бидэнд ихээхэн ашигтай учрыг хэлсэн”<sup>26</sup> хэмээн мэдээлсэн байдаг. Дээрхээс үзвэл, Зөвлөлтийн тал 1947 оны хавар олзлогдсон япончуудыг буцаах асуудлыг тавьж байсан боловч БНМАУ-ын саналыг харгалзан, мөн оны намар хүртэл хойшлуулсан нь тодорхой болж байгаа юм.

Олзлогдсон япон цэргүүд 1947 оны 10 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд 11 удаагийн цуваагаар буцсан бөгөөд нийт 10705 хүнийг үстэй дээл, малгай, гарын бээлий, хөвөнтэй өмд, цамц, дотуур хувцастайгаар ЗХУ-ын хил Наушка-д хүргэн, нэрсийн жагсаалтаар ЗХУ-ын талд хүлээлгэн өгчээ.

**Олзлогдогсдыг ЗХУ-ын талд хүлээлгэн өгөхөөр Улаанбаатараас бүртгэн явуулсан баримтаас үзэхэд:**

1. 1947 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 1-р цуваагаар 1019 хүнийг цолны ялгавар байхгүйгээр,
2. 1947 оны 10 дугаар сарын 16-нд 2-р цуваагаар ахлах дарга 1, дунд дарга 38, бага дарга 137, цэрэг 582, энгийн 110, цагдагч 32, жандармын бага дарга 37, цол ялгавар нь тодорхой биш 102, / замдаа үхсэн 1, өвчтэй үлдсэн 1/ бүгд 1010 хүн,
3. 1947 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 3-р цуваагаар дунд дарга 40, бага дарга 159, цэрэг 578, энгийн 220, цагдагч 7, жандармын бага дарга 2, бүгд 1006,
4. 1947 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 4-р цуваагаар дунд дарга 31, бага дарга 232, цэрэг 615, энгийн 90, цагдагч 24, жандармын дунд дарга 2, бага дарга 6, /замдаа үхсэн 1/ бүгд 999,
5. 1947 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 5-р цуваагаар дунд дарга 64, бага дарга 322, цэрэг 372, энгийн 123, цагдагч 63, жандармын дунд дарга 1, бага дарга 4, /замаас нэмэгдсэн 24, 2-р цуваанаас үлдсэн 1 цэрэг/ бүгд 1001,
6. 1947 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 6-р цуваагаар дунд дарга 54, бага дарга 158, цэрэг 622, энгийн 135, цагдагч 14, жандармын дунд дарга 4, бага дарга 1, бүгд 988,

<sup>26</sup> Ч. Дашдаваа. Японы олзлогдогсод Монголд. УБ., 2013. т. 268-269

7. 1947 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 7-р цуваагаар дунд дарга 57, бага дарга 191, цэрэг 658, энгийн 63, жандармын дунд дарга 2, бага дарга 2, /замдаа үхсэн 1/ бүгд 972,
8. 1947 оны 10 дугаар сарын 22-ны өдөр 8-р цуваагаар дунд дарга 65, бага дарга 135, цэрэг 483, энгийн 51, цагдагч 3, жандармын дунд дарга 1, бага дарга 1, бүгд 739,
9. 1947 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 9-р цуваагаар дунд дарга 49, бага дарга 188, цэрэг 616, энгийн 17, жандармын дунд дарга 1, бага дарга 9, жандармын дарга 20, /замдаа үхсэн 1/бүгд 899,
10. 1947 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 10-р цуваагаар дунд дарга 43, бага дарга 164, цэрэг 556, энгийн 35, жандармын дунд дарга 2, цэрэг 1, бүгд 801,
11. 1947 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 11-р цуваагаар ахлах дарга 7, дунд дарга 63, бага дарга 237, цэрэг 666, энгийн 58, цагдагч 1, жандармын ахлах дарга 2, бага дарга 4, цэрэг 3, /замдаа үхсэн 2, Алтанбулагийн экспортын баазаас нэмэгдсэн 232/ бүгд 1271<sup>27</sup> байжээ.

Олзлогдогсдын дотроос үлдсэн хүн байхгүй, харин 1945 оны дайны үед баривчлагдсан 8 хүнээс 2 нь олзлогдогсодтой хамт буцсан, 1 нь шүүхийн тогтоолоор буудагдсан, 1 нь ял эдэлж байх хугацаандаа нас барсан, 4 хүнийг 1954 оны сүүлийн хагаст БНХАУ-аар дамжуулан буцаасан байна. Нийт 13 япон цэрэг манай улсын хуулиар шийтгэгджээ<sup>28</sup>.

Олзлогдогсдыг буцахад үстэй шинэ дээл 2199, хуучин үстэй дээл 8000, эсгий гутал шинэ 4840 хос, хуучин 4289 хос, монгол, японы үйлдвэрийн шаахай 1988 хос, бээлий 1748 хос, дотуур өмд, цамц шинэ 3804, хуучин 8850, хөлийн ороолтны цагаан ямбуу 3600 метр, өвлийн шаахай 557 хос, япон үстэй гутал 1185 хос, хөвөнтэй өмд шинэ 3214 ширхэг буюу тухайн үеийн ханшаар 2761830 төгрөгний хувцас олгож, замын хүнсийг 20 хоногоор бодож, бүгд 1026177 төгрөгний хүнсний бүтээгдэхүүн олгожээ. Мөн тэднийг тээвэрлэхэд 455 автомашин хэрэглэснээс 22 нь хүнс ачжээ. Олзлогдогсдыг ирж, очиход зориулсан

---

27 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 746, тал 72

28 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 745, тал 75

бензиний зардалд 32408376 төгрөг зарцуулсан<sup>29</sup> баримт байна.

Олзлогдсон япон цэргүүдээс 1945-1947 он хүртэл хугацаанд тус улсад байхдаа өвчнөөр, эс бөгөөс өөр бусад шалтгаанаар үхэх, буудуулах, оргох зэргээр 1613 хүн хорогдсоноос биеэ /амийг/ хорлож үхсэн 4, машинаас онхолдох, усанд унах, шороо чулуунд дарагдах зэрэг гэнэтийн ослоор 38, харуулыг эсэргүүцэж, манаанд буудуулж амь алдсан 4, Шүүх таслах газрын тогтоолоор буудуулсан 1, оргож ор сураггүй алдагдсан 2, бүгд 49, элдэв халдварт өвчнөөр үхсэн 1564, үүний дотор уушигны өвчнөөр 407, гэдэсний өвчнөөр 187, шарлах өвчнөөр 76, бөөсний өвчнөөр 100, зүрхний өвчнөөр 25, дистрофиягаар /дистрофия/ 133, бусад өвчнөөр 536 хүн тус тус нас баржээ. Өвчнөөр нас барсан 1597 хүн дээр судалгаа хийхэд нас барагчдын 588 буюу 36,4 хувь нь уушигны өвчнөөр, 1009 нь бусад өвчнөөр нас барсан болохыг орос, монгол, япон эмч нар тогтоож, хүн нэг бүр дээр бичсэн актыг Японы талд шилжүүлсэн байна<sup>30</sup>.

Монголд нас эцэслэсэн япончуудыг нэр бүхий 17 газар оршуулснаас Дамбадаржаад 835, Хужирбуланд 252, Баруунхараад 58, Угтаалжаргаланд 35, Сүхбаатарг 198, Архустайд 33, Налайхад 12, Шохойцагаан булагт 10, Үхэр чулуутад 4, Алтанбулагт 8, Зүүнхараад 44, Ерөөд 96, Батсүмбэрт 2, Зүүнбүрэнд 19, Төв аймгийн Балжид 1, Архангай аймгийн Өгийнуурт 5, Даландавхарт 25, бүгд 1612 шарил байна.<sup>31</sup> Сураггүй алга болсон 1 япон цэргийг нас барагчдын тоонд оруулан тооцдог байна.

Монголд байсан олзлогдогсдоос ямар нэгэн хэрэгт өртөгдөж 1 жил 6 сараас 10 жил хүртэл хоригдох ял шийтгүүлэн Хорих газарт ял эдэлж байсан цэрэг 10, бага дарга 3, мөн дайны өмнө тагнуулаар хил зөрчиж ял шийтгүүлсэн 2 хүн бүгд 15 хүнийг суллаж, олзлогдогсодтой хамт буцаажээ.

Ял шийтгэгдэн хоригдож байсан японы 3 бага дарга, 10 цэргийн нэрсийг баримтаар тодруулбал:

29 “Монгол Японы харилцаа эрт, эдүгээ” УБ., 2001. т. 129 Э.Лувсанбалдан. Дурьдсан өгүүлэл.”Монгол Японы харилцаа эрт, эдүгээ”. УБ., 2001. т.107-137

30 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 745, тал 71-73

31 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 746, тал 63

1. Ханака. түрүүч цолтой. 1947 оны 6 дугаар сарын 17-нд Хязгаарын цэргийн шүүхээс ажлын багаж эвдсэн учир 5 жил хоригдох ял шийтгүүлсэн.
2. Куручи. түрүүч цолтой. 1947 оны 10 дугаар сарын 26-нд машин мөргөлдүүлсэн хэрэгт 3 жил хоригдох ял шийтгүүлсэн.
3. Като. бага түрүүч. 1947 оны 6 дугаар сарын 17-нд лагериас оргосон хэрэгт 6 жил хоригдох ял шийтгүүлсэн.
4. Таниката. цэрэг. 1946 оны 8 дугаар сарын 14-нд хязгаарын цэргийн шүүхээс машин мөргөлдүүлсэн хэрэгт 1 жил, 6 сар хорих ял шийтгүүлсэн.
5. Фуказава. цэрэг. 1947 оны 6 дугаар сарын 17-нд лагериас оргосон хэрэгт мөн шүүхээс 5 жил хорих ял шийтгүүлсэн.
6. Якизава. цэрэг. 1947 оны 6 дугаар сарын 17-нд лагериас оргосон хэрэгт мөн шүүхээс 7 жил хорих ял шийтгүүлсэн.
7. Мийки. цэрэг. 1946 оны 7 дугаар сарын 22-нд мөн шүүхээс ажлын багаж эвдсэн учир 10 жил хорих ял шийтгүүлсэн.
8. Хосокай. цэрэг. 1947 оны 6 дугаар сарын 17-нд лагериас оргосон хэрэгт 5 жил хоригдох ял шийтгүүлсэн.
9. Ниши. цэрэг. 1947 оны 7 дугаар сарын 3-нд лагериас оргосон хэрэгт 7 жил хорих ял шийтгүүлсэн.
10. Мацумура. цэрэг. 1947 оны 1 дүгээр сарын 12-нд лагериас оргосон хэрэгт 5 жил хорих ял шийтгэгдсэн.
11. Одасаки. цэрэг. 1947 оны 1 дүгээр сарын 8-нд лагериас оргосон хэрэгт 5 жил хорих ял шийтгүүлсэн.
12. Камикава. цэрэг. 1946 оны 9 дүгээр сарын 6-нд лагериас оргосон хэрэгт 10 жил хорих ял шийтгүүлсэн.
13. Кашимото. цэрэг. 1947 оны 10 дугаар сарын 4-нд машинаар морин тэрэг дайрсан учир 2 жил хорих ял шийтгүүлсэн байна.

Мөн лагериас оргож 3 хүн алсан Сакайдо, лагериас оргож, замдаа бусдын морь бууг булаан авч, хүн буудсан Сүзүки, Такабаяши, Фукуда нар шүүхийн тогтоолоор буудагджээ.<sup>32</sup> Эдгээр олзлогдсон цэргүүд 1946 оны 5 дугаар сарын 21-ний шөнө лагериас оргож яваад Төв

32 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 746, тал 60-61

аймгийн Эрдэнэ сумаас баригджээ. Цэргийн коллегийн 1946 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хаалттай хурлаас БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 176-ийн 3, 69-р зүйл ангиар буудан алах ял оноожээ.<sup>33</sup>

Монголд ирсэн япончуудаас тус оронд үлдэх хүсэлт гаргасан нэг хүн байна. Тэр нь 5 дугаар фабрикийн олзлогдсон цэрэг, конторын галч Ивасаки Ичиро юм. Түүний өөрийн гараар бичсэн хүсэлт өдгөө архивт хадгалагдаж байгаа бөгөөд тэрээр мөн нутагтаа буцсан бололтой байна.

### **Дүгнэлтийн оронд цохон тэмдэглэх нь**

Азийг чөлөөлөх дайны явцад ЗХУ олзлон авсан японы цэрэг, албан хаагчдын багахан хэсгийг БНМАУ-д байршуулжээ. Анх 20000 олзлогдсыг хүлээн авахаар бэлтгэл хийж байсан боловч, хэрэг дээрээ 12318-ийг хүлээн авчээ. Тэднийг 1945 оны 11 дүгээр сарын 20-ноос эхлэн 20 хоногийн хугацаанд 6 удаагийн цуваагаар нэрсийн жагсаалтгүйгээр хүлээн авч, 2 жил шахам барилгын голдуу ажилд ажиллуулж байгаад 1947 оны 10 дугаар сарын 10-26-ны хооронд 11 удаагийн цуваагаар 10705 /үүн дээр 1945 онд тагнуулын хэргээр баригдсан 2 япон/ хүнийг Зөвлөлтийн талд буцаан өгчээ.

Олзлогдсон хүмүүсийг 2 жил шахам Монгол нутагт байлгахдаа хорьж байсангүй, харин өөрсдийн нь цэргийн зохион байгуулалтаар япон дарга нар нь удирдаж, манай улсад тэр үед шинээр баригдаж байсан барилгууд дээр туслах ажил, зарим барилгын гадна өрлөг дээр ажиллуулж, зарим хэсгийг нь барилгын материал мод, шохой, туйпуу, чулуу, хайрга бэлтгэх ажилд тусалцуулж байгаад буцаасан байна.

БНМАУ олзны япон хүмүүсийг хоол хүнс, хувцсаар хангах асуудалд ихээхэн анхаарал тавьж ажилласан бөгөөд өөрсдийнхээ хэмжээнд бүх зүйлийг зохистой байлгахад бүх хүч, анхаарлаа хандуулж байсныг архивын баримтууд нотолж байна. Эх газрын эрс тэс цаг агаартай Монголын байдал япон хүмүүсийн эрүүл мэндэд зохих ёсоор нөлөөлж байсан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс олзлогдсон япон цэргүүдийг байрлуулах ба ажиллуулах тухай зааврыг батлан гаргаж, японы олзлогдогсдыг хуучин тасаг, салаа, суман, батальоноор зохион

---

33 ТЕГ.Тусгай архив. Сан 1, хн 745, тал 78

байгуулж, офицеруудыг хөдөлмөрөөс чөлөөлж, хариуцсан хүмүүсийнхээ хөдөлмөрийг зохион байгуулах, сахилга дэг журмыг сахиулах үүрэгтэй ажиллуулсан нь Монгол хэдүйвээр тухайн үед Олон улсын хэмжээнд мөрддөг 1929 оны Конвенцэд нэгдэн ороогүй байсан ч гэсэн тус тунхагийн үзэл санааны дагуу ажлуудаа зохион байгуулж байжээ. Тухайлбал, олзлогдсон эрүүл цэргүүдийн хөдөлмөрийг ашиглахдаа “тэдний нийгмийн байдал болон эзэмшсэн мэргэжлийг харгалзан үзэж зохион байгуулна, олзны офицерууд болон түүнтэй дүйцэх цолтнууд нь хэрэв өөрсдөө зөвшөөрвөл хөдөлмөр эрхлэх бөгөөд харин бага цолтой офицерүүд (унтер-офицер) жирийн олзны цэргүүдийн хөдөлмөрийн үйл ажиллагааг хянах ажил хийж болох бөгөөд чингэхдээ цалин хөлс авна. Олзны цэрэг нь тухайн орон нутгийн хүмүүсийн нэгэн адил ажлын цагтай байх ёстой бөгөөд илүү цагаар ажиллуулахыг хориглоно, хориглох зүйлд заасан: олзны цэргийн хөдөлмөр нь цэрэг дайны зориулалттай барилга барих зэрэгт ашиглагдах ёсгүй, ямар ч олзны цэрэг өөрт нь эрүүл мэндийн хувьд тохирохгүй болон эрүүл мэндэд нь муугаар нөлөөлөх хөдөлмөр эрхлэх ёсгүй” гэсэн заалтууд нь манайд эчнээ хэрэгжиж байжээ.

ЗХУ-ын холбоотон Монгол улсад энгийн япон хүмүүс олзны цэргүүдийн тоонд орон ирсэн нь 1941 оны 7 дугаар сарын 1-нд Зөвлөлтийн Ардын Комиссариатын газраас Цэргийн олзлогдогсдын талаарх батлан гаргасан баримт бичигт заасан “дайнд олзлогдогч гэдэг нь: а) ЗХУ-тай дайны байдалд байгаа орны зэвсэгт хүчинд хамаарч, дайны ажиллагааны үед баривчлагдсан хүмүүс болон Зөвлөлтийн газар нутаг дээрх тусгаарлагдсан тэдгээр орнуудын иргэд, б) дайсны зэвсэгт хүчинд үл хамаарах боловч зэвсэглэсэн бүлэгт хамааран илт зэвсэгтэй явж буй этгээд, в) цэргийн үйл ажиллагааны явцад олзлогдсон сурвалжлагчид, ханган нийлүүлэгч, цэргийн хамт зөвшөөрөл бүхий бусад хүмүүс болон дайсны хөлөг онгоцыг дагалдан яваа энгийн иргэд зэрэг болно<sup>34</sup> гэж заасны дагуу баривчлагдан ирсэн хүмүүс байжээ. Гэтэл Өрнөдийн орнууд “Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай” гэрээнд нэгдэн орсон учир цэргийн бус энгийн иргэдийг олзлох ёсон үгүй аж. Монголд олзлогдсон цэргийн тоонд орон ирсэн Манжуурын Жэхэ мужид амьдарч байсан жирийн япон иргэд тус улсад хандан

34 Военнопленные в СССР. 1939-1956, т. 66

чөлөөлж өгөхийг хүсэн бичсэн өргөдлүүд өдгөө ч хадгалагдаж байна<sup>35</sup>.

Олзлогдсон олон япон хүнийг 2 жил Улаанбаатар хотын барилга, барилгын материал үйлдвэрлэлийн ажилд ажиллуулсан нь хотжих үйл явц эхэлж байсан нөхцөлд дадлага туршлагатай ажиллах хүчнээр хангаж, нийслэл хотын төв хэсгийн өнөөгийн өнгө төрхийг илтгэсэн засаг захиргаа, олон нийтийн томоохон барилгуудын үндэс суурийг тавих ажилд гар бие оролцсон гавьяатай амуй.

Жич: Монголд байсан япон хүмүүс өөрсдийн байдыг Монголын эрх баригч нарт захидал бичиж илтгэж, тусламж хүссэн захидлууд өдгөө тус улсын архивуудад судлаачаа хүлээсээр хадгалагдаж байна. Эдгээр баримтуудыг судлан үзэх аваас ихэд сонирхолтой дүр зураг гарна гэдэгт итгэлтэй байна.

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, НОМ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ**

### 1. Сурвалж.

ТЕГ-ын Тусгай архив.

Ф 1, х 6, д 1, хн 2

Ф 1, х 6, д 1, хн 4

Ф 1, х 6, д 1, хн 9

Ф 1, х 6, д 1, хн 10

Ф 1, х 6, д 1, хн 22

Ф 1, х 6, д 1, хн 24

Ф 1, х 6, д 1, хн 26

Ф 1, х 6, д 1, хн 28

Ф 1, х 6, д 1, хн 54

Ф 1, х 6, д 1, хн 55

Ф 1, х 6, д 1, хн 56

Ф 1, х 6, д 1, хн 57

Ф 1, х 6, д 1, хн 58

Ф 1, х 6, д 1, хн 59

---

35 Гадаад хэргийн төв Архив. Ф-59, хн-031, т.34

- Ф 1, х 6, д 1, хн 124
- Ф 1, х 11, д 5, хн 170
- Ф 1, х 11, д 5, хн 311
- Ф 1, х 6, д 1, хн 329
- Ф 1, х 6, д 1, хн 334
- Ф 1, х 6, д 1, хн 335
- Ф 1, х 6, д 1, хн 337
- Ф 1, х 6, д 1, хн 349
- Ф 1, х 6, д 1, хн 350
- Ф 1, х 6, д 1, хн 351
- Ф 1, х 6, д 1, хн 352
- Ф 1, х 6, д 1, хн 353
- Ф 1, х 6, д 1, хн 354
- Ф 1, х 6, д 1, хн 356
- Ф 1, х 6, д 1, хн 363
- Ф 1, х 6, д 1, хн 376
- Ф 1, х 11, д 5, хн 392
- Ф 1, х 11, д 5, хн 592
- Ф 1, х 11, д 5, хн 593
- Ф 1, х 6, д 1, хн 423
- Ф 1, х 11, д 5, хн 475
- Ф 1, х 11, д 5, хн 476
- Ф 1, х 6, д 1, хн 743
- Ф 1, х 6, д 1, хн 745
- Ф 1, х 6, д 1, хн 746

2. Гадаад хэргийн төв Архив.

- Ф-59, хн-031

***Судалгааны бүтээл.***

1. Ц.Батбаяр. “Монгол ба Япон XX зуунд”. УБ., 2012
2. Ч.Дашдаваа. “Японы олзлогдогсод Монголд”. УБ., 2013
3. С.Идшинноров. “Бүтээлийн чуулган” дэд боть. УБ., 2013 он.
4. Ч.Лувсан-Очир. “Дайны дараа Монголд байсан япончуудын хувь заяа” УБ., 1998
5. “Монгол Улсын түүх” V боть. УБ., 2003
6. “Монгол Японы харилцаа эрт эдүгээ” УБ., 2001 он
7. Г.Мягмарсамбуу. “Чөлөөлөх дайн ба голомтоо зорьсон монголчууд”. Чөлөөлөх дайны 70 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл.
8. Международное правосистемномизложении /Ф.Лист.–Юрьев/ М., 1909
9. Кузнецов, С.И. Японцы в сибирском плену (1945-1956 гг.). Иркутск, 1997
10. Военнопленные СССР. 1939-1956. Документы и материалы / Сост. М.М. Загорулько
11. С.Г.Сидоров, Т.В.Царевская; Подред. М.М. Загорулько. М.: Логос, 2000
12. Военно-исторический журнал. М., 1990, № 9, т. 45
13. Карасев С.В. История плена: советско-японская война и ее последствия: 1945-1956 годы. Иркутск, 2007

***Хэвлэл***

1. “Өдрийн сонин”. 2011.07.04. №162 /3864/